

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН 2018 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН АУДИТ**

АГУУЛГА

2	Аудитын тайлан	1
2.1	Оршил	1
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	1
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	2
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	2
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	3
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	3
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	4
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	4
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	5
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	5
	Цалингийн зардлын талаар авч үзнэ.	5
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	5
	Тус байгууллага нь үндсэн үйл ажиллагаанаас орлого олдоггүй бөгөөд 100 хувь улсын төсвөөс санхүүждэг газар юм.	6
2.11	Шилэн дансны мэдээлэл.....	6
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	6
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	6
3	Менежментийн захидал	7
3.1	Балансын данстай холбоотой асуудал.....	7
3.2	Аудит хийсэн санхүүгийн тайлан	8
3.3	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	8
3.4	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	9
3.5	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	11
3.6	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	13
3.7	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	14
	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	0

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2019.02.25 № 06/251
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлсэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн захирал Т.Ариунбаатар танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 12 дугаар сарын 3-наас 2019 оны 2 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 2 дугаар сарын 22-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, “Баян ташаагийн эх Аудит” ХХК-ийн аудитор Т.Хоролсүрэн, Д.Түмэндэмбэрэл, чанарын хяналтын менежер Ч.Чимгээ, аудиторын туслах Д.Балжирдорж, Г.Хишигдулам нар хариуцаж хэрэгжүүлэв.

Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан “Баян ташаагийн эх Аудит” ХХК-д 2019 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 21 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв нь галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй, шуурхай, найдвартай, үр ашигтай удирдлага, зохицуулалтын нэгдсэн тогтолцоог хөгжүүлнэ гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Зам, тээврийн хөгжлийн яамны тодорхойлсноор Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн үйл ажиллагааны чиглэл нь галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, галт тэрэгний хөдөлгөөний удирдлага, зохицуулалтын системийг боловсронгуй болгох, хөдлөх бүрэлдэхүүний ашиглалт хангалтыг сайжруулах, тээвэрлэлтийн үйл ажиллагааг бүрэн хянах, хяналт гэж тодорхойлсон юм.

Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль
- Төмөр замын тээврийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байгаа эрх зүйн орчны томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acoulous” програм хангамж ашигладаг байна.

Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 12 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 12 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь төсөвт байгууллага нь үйл ажиллагааны нийт зардлаа төсөвлөж, үүний дагуу өөрийн үйл ажиллагаанаас болон төсвөөс орлого төвлөрүүлэн зардлаа санхүүжүүлдэг. Ашгийн бус зардалд суурилан санхүүгийн үр дүнг төсөвлөдөг байгууллагын хувьд нийт зардлыг суурь болгон авч үзэх нь тохиромжтой юм.

Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн материаллаг байдлын суурийг 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 617,203.0 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 6,172.0 мянган төгрөгөөр тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь эрсдэл бага гэж үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 3 чиглэлээр аудитын 12 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 1 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 11 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэсэн бөгөөд аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийгээгүй.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

				/мянган төгрөг/
№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1	1,358.8	
	Дүн	1	1,358.8	

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудал байхгүй байна.

2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Цалингийн зардлын талаар авч үзнэ.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал үгүй байна.

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 1 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 712,647.4 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 699,515.5 мянган төгрөг буюу 98.2 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлын 775.1 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын 374.3 мянган төгрөг хэмнэгдсэн нь сул орон тооны албан тушаал нөхөгдөх хугацаанд хэмнэгдсэн, мөн хангамж, бараа материалын зардал 8,104.8 мянган төгрөг хэмнэгдсэн нь бараа материалын худалдан авалтыг хийхдээ үнийн хамгийн бага өртөгтэйг сонгох, шуудан хүргэлтийг биеэр хүргэж өгөх, дотоод албан бичгийг цахимжуулах зэргээр зардлыг бууруулсан, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 3,219.2 мянган төгрөг, улсын мэдээллийн маягт хэвлэх бэлтгэх зардал 2,979.7 мянган төгрөг хэмнэгдсэн нь шаардлагатай ажил үйлчилгээний төлбөрийг хамгийн бага өртөг зардалтайг сонгох, албан бланк, хэвлэмэл материал, сургалтын гарын авлагыг дотооддоо хэвлэх зэргээр хэмнэсэнтэй холбоотой.

Тус байгууллага нь үндсэн үйл ажиллагаанаас орлого олдоггүй бөгөөд 100 хувь улсын төсвөөс санхүүждэг газар юм.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Балансын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Кассын зарлагыг анхан шатны баримттай тулган шалгахад 1,358.8 мянган төгрөгийг анхан шатны баримтын бүрдэлгүй зарлагадсан байна.

Энэ нь “үнэн зөв байх” батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Мөнгөн хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналт сул, дотоод хяналт муу байх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийг мөрдөж ажиллах мөрдөж ажиллах

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Сканердсан баримтыг анхан шатны баримт бүрдэлтэнд ашигласан байсныг шалгалтын явцад залруулж эх баримтыг шалгуулсан. Цаашид хуулийн зүйл заалтыг дагаж хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 дугаар сарын 1-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

3.2 Аудит хийсэн санхүүгийн тайлан

3.3 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан.

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	15,650,999.00	31,754,248.50
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	00.00
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	00.00	00.00
31110	Төгрөг	00.00	00.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	00.00
3121	Төгрөг	00.00	00.00
31211	Төрийн сангийн харилцах	00.00	00.00
33	АВЛАГА	8,496,200.00	8,496,200.00
335	Бусад авлага	8,496,200.00	8,496,200.00
3351	Байгууллагаас авах авлага	8,496,200.00	8,496,200.00
35	БАРАА МАТЕРИАЛ	7,154,799.00	23,258,048.50
351	Түүхий эд материал	5,633,482.00	20,202,626.50
35110	Тусгай зориулалттай материал	5,633,482.00	20,202,626.50
354	Хангамжийн материал	1,521,317.00	3,055,422.00
35410	Бичиг хэргийн материал	717,385.00	2,080,655.00
35460	Хүнсний материал	00.00	170,835.00
35470	Бусад хангамжийн материал	803,932.00	803,932.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	43,495,965.52	1,727,846,933.15
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	43,495,965.52	1,727,846,933.15
392	Биет хөрөнгө	35,675,965.40	37,266,933.15
39203	Авто-тээврийн хэрэгсэл	57,338,000.00	57,338,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-38,742,968.03	-48,299,301.35
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	25,742,479.00	43,222,179.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-23,960,762.17	-27,456,994.26
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	27,187,687.18	27,187,687.18
39208	Хуримтлагдсан элэгдэл	-11,888,470.58	-14,724,637.42
393	Биет бус хөрөнгө	7,820,000.12	1,690,580,000.00
39301	Програм хангамж	15,081,000.00	85,551,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-7,260,999.88	-10,331,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	00.00	1,615,360,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	59,146,964.52	1,759,601,181.65
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	10,417,874.54	00.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	10,417,874.54	00.00
413	Өглөг	10,417,874.54	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	48,729,089.98	1,759,601,181.65
51	Засгийн газрын хувь оролцоо	48,729,089.98	1,759,601,181.65
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	00.00	1,615,360,000.00
51101	Өмч: - төрийн	00.00	00.00
51102	- хувийн	00.00	00.00
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	00.00	1,615,360,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	48,729,089.98	144,241,181.65
51210	Өмнөх үеийн үр дүн	48,729,089.98	48,729,089.98
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	95,512,091.67
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	59,146,964.52	1,759,601,181.65

3.4 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан.

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	530,488,181.25	712,715,100.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	924,481.25	67,700.00
120	Нийтлэг татварын бус орлого	924,481.25	67,700.00
120009	Бусад орлого	00.00	67,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	529,563,700.00	712,647,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	523,563,700.00	712,647,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	523,563,700.00	712,647,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,000,000.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,000,000.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	552,640,411.12	617,203,008.33
21	УРСГАЛ ЗАРДАЛ	552,640,411.12	617,203,008.33
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	541,000,266.69	601,521,097.63
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	340,543,789.98	323,942,210.12
210101	Үндсэн цалин	292,587,739.76	217,206,025.46
210102	Нэмэгдэл	38,971,650.22	89,315,552.13
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,984,400.00	17,420,632.53
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,570,884.56	39,841,960.31
210201	Тэтгэврийн даатгал	30,671,425.88	26,924,190.79
210202	Тэтгэмжийн даатгал	1,239,120.84	2,975,103.58
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,574,189.57	2,685,289.42
210204	Ажилгүйдлийн даатгал	636,418.44	798,491.74
210205	Эрүүл мэндийн даатгал	3,449,729.84	6,458,884.78
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	101,022,600.00	121,792,846.00
210304	Байрны түрээс	101,022,600.00	121,792,846.00
2104	Хангамж, бараа материалын зардал	32,057,146.57	34,414,106.33
210401	Бичиг хэрэг	9,326,724.00	15,406,399.00
210402	Тээвэр, шатахуун	6,923,400.00	11,650,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,786,065.57	6,029,353.13
210404	Ном, хэвлэл	00.00	106,413.20
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,256,430.00	1,221,941.00
210408	Бараа материал акталсны зардал	7,764,527.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,233,700.00	3,456,386.50
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	464,250.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	38,036.50
210604	Урсгал засвар	3,233,700.00	2,954,100.00
2107	Томилолт, зочны зардал	3,532,872.00	18,490,890.00
210702	Дотоод албан томилолт	3,532,872.00	18,490,890.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,886,400.00	22,987,766.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	18,788,010.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,485,000.00	1,485,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	490,000.00	564,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	114,500.00	144,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	45,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	198,000.00
210807	Газрын төлбөр	110,900.00	111,056.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	686,000.00	1,651,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,152,873.58	36,594,932.37

Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,330,000.00	990,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,200,000.00	16,646,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	17,622,873.58	18,958,732.37
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,640,144.43	15,681,910.70
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,115,000.00	2,550,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,615,000.00	2,550,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,500,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,525,144.43	13,131,910.70
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,525,144.43	13,131,910.70
213304	Хөрөнгийн	00.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-22,152,229.87	95,512,091.67
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	241,195.92	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-241,195.92	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-22,393,425.79	95,512,091.67

3.5 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан.

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	529,563,700.00	712,715,100.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	67,700.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	67,700.00
120009	Бусад орлого	00.00	67,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	529,563,700.00	712,647,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	523,563,700.00	712,647,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	523,563,700.00	712,647,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,000,000.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,000,000.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	524,613,700.00	624,765,400.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	524,613,700.00	624,765,400.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	512,973,555.57	609,083,489.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	331,258,500.00	334,360,084.66
210101	Үндсэн цалин	283,302,449.78	227,623,900.00
210102	Нэмэгдэл	38,971,650.22	89,315,552.13
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,984,400.00	17,420,632.53
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,438,300.00	39,841,960.31
210201	Тэтгэврийн даатгал	36,438,300.00	39,841,960.31
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	101,022,600.00	121,792,846.00
210304	Байрны түрээс	101,022,600.00	121,792,846.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,932,683.57	37,045,551.33
210401	Бичиг хэрэг	8,952,190.00	10,684,009.00
210402	Тээвэр, шатахуун	6,923,400.00	11,650,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,786,065.57	6,135,766.33
210404	Ном, хэвлэл	00.00	7,183,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,271,028.00	1,392,776.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,071,600.00	9,029,191.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,909,400.00	4,415,091.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	565,500.00	1,660,000.00
210604	Урсгал засвар	3,596,700.00	2,954,100.00
2107	Томилот, зочны зардал	3,532,872.00	18,490,890.00
210702	Дотоод албан томилот	3,532,872.00	18,490,890.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,527,000.00	25,886,766.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	18,788,010.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,485,000.00	1,485,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	490,000.00	564,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	114,500.00	144,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	45,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	484,000.00
210807	Газрын төлбөр	110,900.00	111,056.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,326,600.00	4,264,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,190,000.00	22,636,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	990,000.00	990,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,200,000.00	21,646,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,640,144.43	15,681,910.70

2132	Бусад урсгал шилжүүлэг	10,115,000.00	2,550,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,615,000.00	2,550,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,500,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,525,144.43	13,131,910.70
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,525,144.43	13,131,910.70
213304	Хөрөнгийн	00.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>4,950,000.00</u>	<u>87,949,700.00</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	00.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	4,950,000.00	87,949,700.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,950,000.00	87,949,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	4,950,000.00	87,949,700.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,950,000.00	87,949,700.00
2260	Гадаад эх үүсвэрээр	00.00	00.00
226001	Гадаад эх үүсвэрээр	00.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-4,950,000.00</u>	<u>-87,949,700.00</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

3.6 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан.

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	71,122,515.77	71,122,515.77
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	71,122,515.77	71,122,515.77
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-22,393,425.79	-22,393,425.79
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	48,729,089.98	48,729,089.98
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	48,729,089.98	48,729,089.98
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	1,615,360,000.00	00.00	00.00	1,615,360,000.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	95,512,091.67	95,512,091.67
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,615,360,000.00	00.00	144,241,181.65	1,759,601,181.65

3.7 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан.

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	712,647,400.00	699,515,489.30	13,131,910.70	98.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ	712,647,400.00	699,515,489.30	13,131,910.70	98.16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	709,984,100.00	696,965,489.30	13,018,610.70	98.17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	335,135,100.00	334,360,084.66	775,015.34	99.77
210101	Үндсэн цалин	227,623,900.00	227,623,900.00	-	100.00
210102	Нэмэгдэл	89,542,700.00	89,315,552.13	227,147.87	0.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,968,500.00	17,420,632.53	547,867.47	96.95
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,216,300.00	39,841,960.31	374,339.69	99.07
210201	Тэтгэврийн даатгал	27,078,700.00	39,841,960.31	(12,763,260.31)	147.13
210202	Тэтгэмжийн даатгал	3,284,400.00	00.00	3,284,400.00	0.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,627,500.00	00.00	2,627,500.00	0.00
210204	Ажилгүйдлийн даатгал	656,900.00	00.00	656,900.00	0.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,568,800.00	00.00	6,568,800.00	0.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	121,822,600.00	121,792,846.00	29,754.00	99.98
210304	Байрны түрээс	121,822,600.00	121,792,846.00	29,754.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	45,150,400.00	37,045,551.33	8,104,848.67	82.05
210401	Бичиг хэрэг	11,447,400.00	10,684,009.00	763,391.00	93.33
210402	Тээвэр, шатахуун	12,242,100.00	11,650,000.00	592,100.00	95.16
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	12,363,400.00	6,135,766.33	6,227,633.67	49.63
210404	Ном, хэвлэл	5,750,000.00	7,183,000.00	(1,433,000.00)	124.92
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	26,516,100.00	26,508,891.00	7,209.00	99.97
210601	Багаж, техник, хэрэгсэл	19,736,100.00	21,894,791.00	(2,158,691.00)	110.94
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,494,800.00	1,660,000.00	834,800.00	
210604	Урсгал засвар	4,285,200.00	2,954,100.00	1,331,100.00	68.94
2107	Томилолт, зочны зардал	18,957,400.00	18,490,890.00	466,510.00	97.54
210702	Дотоод албан томилолт	18,957,400.00	18,490,890.00	466,510.00	97.54
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	99,508,300.00	96,289,066.00	3,219,234.00	96.76
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	49,850,000.00	50,009,310.00	(159,310.00)	100.32
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,485,000.00	1,485,000.00	-	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	564,300.00	564,300.00	-	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	257,400.00	144,500.00	112,900.00	56.14
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	45,000.00	45,000.00	-	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	39,950,000.00	39,665,000.00	285,000.00	99.29
210807	Газрын төлбөр	112,000.00	111,056.00	944.00	99.16
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	7,244,600.00	4,264,900.00	2,979,700.00	58.87
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22677900.00	22636200.00	41,700.00	99.82
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	990,000.00	990,000.00	-	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	21,687,900.00	21,646,200.00	41,700.00	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2663300.00	2,550,000.00	113,300.00	95.75
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,663,300.00	2,550,000.00	113,300.00	95.75
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,663,300.00	2,550,000.00	113,300.00	95.75
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ	712,647,400.00	712,647,400.00	-	100.00

Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	ҮҮСВЭР				
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	712,647,400.00	712,647,400.00	-	100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	712,647,400.00	712,647,400.00	-	100.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	00.00	00.00		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	00.00	00.00		
610001	Төсвийн байгууллага	00.00	00.00	00.00	00.00
610002	Төсвөөс гадуур байгууллага	00.00	00.00		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	25.00	25.00		
620001	Удирдах ажилтан	01.00	01.00		
620002	Гүйцэтгэх ажилтан	24.00	24.00		
620003	Үйлчлэх ажилтан	00.00	00.00		
620004	Гэрээт ажилтан	00.00	00.00		

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2019.02.25	Аудитын нэр:	2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан	Аудитын код:	САГ-2019/288/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв			Мянган төгрөгөөр	

Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
		Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5
Кассын зарлагыг анхан шатны баримттай тулган шалгахад 1,358.8 мянган төгрөгийг анхан шатны баримтын бүрдэл дутуугаар зарлагдсан байна	1,358.8	Зөвлөмж	Захирал	Т.Ариунбаатар
Зөвлөмжийн дүн	1,358.9			